

ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНГИЙН ХУРЛЫГ ХААЖ ХЭЛСЭН ҮГ

Өнөөдөр бид нар тодорхой хугацаанд бэлдэж, зохион байгуулсан энэ олон улсын эрдэм шинжилгээний хурал өөрийнхөө үүргийг биелүүллээ гэж үзэж байна. Манай хуралд үндсэндээ 10 гаруй илтгэл тавигдлаа, энэ илтгэлд Монгол-Оросын харилцааны түүх, сургамж, ирээдүйн чиглэлийн талаар олон сайхан санаа дүгнэлт бүхий илтгэлүүд байсныг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Манай хуралд хүрэлцэн ирж оролцсон, өөрийнхөө үгийг хэлсэн бидний хүндэт найз сансрын нисгэгч В.В.Горбаткод талархал илэрхийлж байна. Мөн хурлын үндсэн илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн Найрамдлын нийгэмлэгүүдийн холбооны тэргүүн сансрын нисгэгч, баатар, УИХ-ын гишүүн Гүррагчаа гуайд талархал илэрхийлж байна.

Өнөөдөр манай хуралд олон хүмүүс оролцсон, тэр тусмаа одоо энэ танхимд сууж байгаа манай хоёр орны найрамдал, хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэхэд өөрийн оюун ухаан, сэтгэл зүрхээ зориулж байсан манай ахмад, дунд үеийн төлөөлөгчид олон байна. Тухайлбал, анхны Ерөнхийлөгч Очирбат гуай, МАХН-ын дарга асан Очирбат гуай энд сууж байна, мөн ОХУ-д элчин сайдаар ажиллаж байсан манай нэртэй төрийн ажилтан Готов гуай оролцлоо, мөн манай хуралд Монголын орос хэлний холбооны тусгай сонгуультан, идэвхтэн, Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн эрхлэгч доктор, профессор Наранцацрал, ШУА-ийн эрдэмтэн-нарийн бичгийн дарга доктор, профессор Адъяа оролцсон, мөн доктор Энхбаатар оролцсон. Уржигдархан Монгол Улсын гавъяат багш цолоор шагнуулсан Цогзолмаа доктор оролцон энд сууж байна. Бидний хуралд идэвхитэй оролцсон бүх хүмүүст хуралд оролцсон оролцогчдынхоо нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна.

Тэгэхээр Монгол-Оросын ард түмнүүдийн найрамдал олон зууны түүхтэй, хоёр үндэстэн, хоёр улсыг хүчирхэгжэн хөгжихөд аль аль нь бие биендээ тус дэм болж хөгжиж явсан ийм түүхэн харилцаатай ард түмнүүд юм. Тэр ч байтугай, дэлхийн соёлын түүхийг бүтээхэд манай хоёр ард түмэн хамтарч гар бие оролцож байсныг түүх мартаггүй, улам тодорсоор байна. Дэлхийн алдарт торгоны замыг цайны замаар хөгжүүлсэн ард түмэн бол Монгол, Оросын ард түмэн. XIII зуунд Оросын салан тасархай байсан вант улсуудыг нэгтгэж хүчирхэг Оросын төрийг байгуулахад хамгийн их нөлөө үзүүлсэн ард түмэн бол Монголын ард түмэн, тэр үеийн Монголын хаадууд. XX зуунд Монгол Улс тусгаар тогтнолоо олж, монгол үндэстэн цэцэглэн хөгжиж, өсөн дэвжихэд тус болсон, Монголын нийгмийн оюуны соёлыг хөгжүүлэхэд

үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан ийм ард түмэн бол Оросын ард түмэн, бид энэ ард түмнийг мартаж ёсгүй, энэ ард түмэнтэй тогтоосон харилцаагаа хайрлан нандигнаж цаашид хөгжүүлэх ийм үүрэг бидний үеийнхэнд ноогдсон.

Цаашдын хамтын ажиллагаанд XXI зуунд даяршлын үед улам боловсронгуй болгож хөгжүүлэх асуудал бидний дараагийн үеийнхний авч явах ёстой асуудал. Энэ бол зүрх сэтгэлийн гүн бат холбоон дээр тогтсон энэ найрамдал бол ямар нэгэн түр зуурын бэрхшээлд автахгүйгээр цаашид хөгжинө гэдэг нь гарцаагүй зүйл юм. Ер нь хөршөө сонгодоггүй гэж монголчууд ярьдаг. Тэгэхээр иргэд хоорондын энэ өргөн харилцаа XXI зууны Монголын ирээдүй, Орос орны дэлхийн түвшинд эзлэх байр суурь хамтын ажиллагаанд нь шинэ агуулгаар улам баяжиж, нэгэн гол салаа болж улам хүчирхэгжиж хөгжинө гэдэгт бид бүрэн дүүрэн итгэж байгаа.

Өнөөдрийн тавьсан илтгэлүүдэд хамтын ажиллагаанд байгаа бэрхшээл, түүнийг даван туулах, нэн ялангуяа хил орчмын болон бүс нутгийн, эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагаа, оюуны салбар дахь хамтын ажиллагаа, цаашид анхаарах ёстой асуудлууд, шийдвэрлэх асуудлуудын талаар тодорхой дүгнэлтүүд гарлаа. Үүнийг манай төр засгийн удирдлага, бодлого боловсруулагчид бас анхаарч үзнэ байх гэдэгт найдаж байна. Ингээд хурлын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье, та бүхэнд дахин баяр хүргэж, та бүгдийн ажил үйлс, амьдралд чинь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна.

“МОКС 60” гэрэл зургууд



Монголын анд нөхдийн нийгэмлэгийн тэргүүн, ЗХУ ба БНМАУ-ын баатар, сансарын нисгэгч Виктор Васильевич Горбатко



Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэлийн тэргүүн, УИХ-ын гишүүн, сансарын нисгэгч, ЗХУ ба Монгол улсын баатар Ж.Гүррагчаа



Боловсрол, соёл, шинжлэх ухааны
дэд сайд С.Төмөр-Очир



Эрхүүгийн Их сургуулийн түүхийн
факультетын декан, түүхийн шинжлэх
ухааны доктор Е.И.Лиштованный



ШУА-ийн Олон улс судлалын
хүрээлэнгийн Орос судлалын
секторын эрхлэгч, түүхийн шинжлэх
ухааны доктор О.Батсайхан



МЗНН-ийн Төв зөвлөлийн орлогч дарга асан,
доктор, профессор Б.Сумьяа



Буриадын Их сургуулийн Улаанбаатар
дахь салбарын захирал,
сурган хүмүүжүүлэх ухааны дэд доктор,
доцент Б.Ч.Хасаранов



Монгол-Оросын хамтарсан сургуулийн
захирал, доктор (Ph.D) Ж.Соронзон



ОХУ-ын БН Буриад Улсын
Монгол дахь
Төлөөлөгчийн газрын
тэргүүн, профессор
Н.И.Атанов

*Монгол Улсын
Боловсролын их
сургуулийн Дэлхийн
түүхийн тэнхимийн
эрхлэгч, доктор
Д.Наранцэцэг*

